



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/99

Хархорин сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Сумын ой бүхий 4000 га талбайд “Аглаг ой” ХХК ойн хортон шавж устгах тэмцлийн ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан 4 дүгээр багийн Баянгол, Их арцат, Бага арцат, 8 дугаар багийн Нуурын гозгор, Арцатын бэлчир Бага нарийн гэх ойн сан бүхий газруудад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Хорио цээр тогтоосон ойн сан бүхий газарт гадаад, дотоодын аялагч, иргэд, мал оруулахгүй байхыг малчин, мал бүхий иргэд, аялагч нарт сурталчлан ажиллахыг багийн Засаг даргад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Баатарсүрэн), Байгаль хамгаалагч (Н.Төгөлдөр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ

401100197